

Буддын шашны нэр томъёог орчуулах асуудалд

Д.Бүрнээ /МУИС, МХСС/

Түлхүүр үг: буддын шашны нэр томъёог орчуулах уйгарын уламжлал, “Мэргэд гарахын орон” нэр томъёоны толь; нэр томъёог үгчлэн орчуулах, утга дүйлгэн орчуулах, зээлдэн авах арга, нэр томъёог орчуулах хандлага

Монголын ард түмэн төвд хэлнээс ном судар орчуулах талаар арвин туршлага хуримтлуулжээ. Энэ нь бүр 13-14 зууны үеэс буддын шашин, гүн ухаан, эрдэм ухааны олон аймгийн ном зохиолыг төвд хэлнээс орчуулж, хэдэн арван орчуулагч, гүүш нар төрөн гарч, монгол орчуулгын сан хөмрөгийг бүтээл туурвилаараа баяжуулсантай холбоотой. Орчуулгын арвин бүтээл нь монгол орчуулга судлалын үнэ цэнэтэй хэрэглэгдэхүүн болж байна. Энэхүү өгүүлэлд эн тэргүүн Буддын шашны нэр томъёог төвд хэлнээс орчуулж байсан уламжлалын талаар авч үзэхийн сацуу өнөө үед буддын шашны нэр томъёог төвд, англи хэлнээс орчуулах талаар гарч буй зарим ололт амжилтын талаар өгүүлэхийг зорьсон болно.

Төвд хэлнээс ном судар орчуулж эхэлсэн 13-14 зууны үеэс буддын шашны үг хэллэг, нэр томъёог орчуулах талаар монголчууд туршлага багатай байсан тул уйгарчуудын санскрит хэлнээс орчуулж байсан уламжлалыг баримталсан тухай эрдэмтэн судлаачид бичиж тэмдэглэжээ. Тухайлбал оросын эрдэмтэн Ю.Н.Рерих “...монголчууд Уйгараар дамжуулан Бурханы шашны соёлтой танилцахдаа согд, уйгар хэлнээ бэлхнээ орчихоод байсан шашны чанартай, самгардаас зээлдэн авсан үг олныг авч хэрэглэх болсныг бид мэднэ. Тийнхүү хэлхээ холбоо тогтоосон тэр цагт гүн ухааны нэр томъёог төдий л их өргөн хэрэглэхгүй байсан учир согд, уйгар хэлэнд орсон самгардаас зээлдэн авсан бурханы шашны нэр томъёог монголчлолгүй тэр хэвээр нь самгардаар нь хэрэглэх хандлагатай байжээ” гэж бичжээ¹⁹. Энэ үед зээлдсэн махбод, вишай, агшин, голди, галав, сансар, судар, шастир, тарни, арш, нирваан, нисваанис, санваар, шагшаабад, тидши, бодь, шраваг, брадигабуд гэх мэт олон үг өнөө үед уламжлан ирсэн байна. Монгол орноо буддын шашин хүчтэй дэлгэрч эхэлсэн XVI-XVII зууны үеэс олон тооны сүм хийд байгуулагдан түүнд лам нар олноор шавилан сууж, хүрээ хийд шашин номын төдийгүй эрдэм соёлын төв болж байв. Монголын ард түмний оюунлаг залуучууд Төвдийн Лхас, Гүмбүм зэрэг буддын шашны томоохон хийдүүдэд очиж, төвдийн эрдэмтэн багш нарт шавь орж, буддын утга зохиолыг судалж, буддын шашин, гүн ухаан, анагаах ухаан, дуун ухаан зэрэг их бага таван ухааныг хамарсан

¹⁹ Л.Хүрэлбаатар, Орчуулгын товчоон (Сонгодог орчуулгын зарчим, уран чадварын асуудалд), Улаанбаатар, 1995, 17.

арвин их зохиолыг төвд хэлээр туурвисан нь 20 дугаар зуун гарахад хэдэн зуун боть бүтээл болжээ. Судлаачдын үзэж байгаагаар төвд хэлээр бүтээлээ туурвиж байсан монгол мэргэдийн тоо 200 гарч байгаа бөгөөд тэдний бичсэн зохиол монгол үндэстний төдийгүй төвдийн утга зохиолыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Мөн үед XIV зуунаас орчуулж эхэлсэн буддын шашин, утга зохиолын их цоморлиг Ганжуур, Данжуурыг төвд хэлнээс орчуулж дуусгах, улмаар ариутган шүүж барлах ажлыг монголын мэргэд ихээхэн хүчин чармайлт гаргаж гүйцэтгэсэн бөгөөд энэ нь "цөл говь нутагтай гурван сая орчим нүүдэлчин монголчуудын гадаад дотоодын бэрх давхар дарлагдлын үед бүтээж чадсан гайхаж биширмээр соёлын өв тэгш амжилт болсон билээ"²⁰. Эрдэм ухааны арван аймгийн ном зохиолын цоморлиг болох 226 боть Данжуурыг орчуулахад төрөл бүрийн эрдэм ухааны нэр томъёог боловсруулах шаардлагатай болсны учир олон эрдэмтэн хүч хамтарч "Мэргэд гарахын орон" нэрт толь бичгийг 1742 онд зохиожээ.

Тус толь бичиг бүтцийн талаас авч үзвэл барамид, мадхьямика, авидарма, винай, тогтоосон таалал, тарни, учир шалтгааны ухаан, урлахуй ухаан, дууны ухаан, тэжээхүй ухаан, шинэ хуучин дохионы аймаг гэсэн 11 хэсгээс бүрдэх зүйл хуваасан толь болно. Олон эрдэм ухааны аймагт багтах төвд монгол нэр томъёог ийнхүү журамлан тогтоосон нь монгол орчуулгын түүхэнд томоохон үйл явдал болсон билээ. Зүйл хуваасан толь бичиг бол тухайн салбар ухааны үүсэл хөгжил, бүтэц агуулгыг судлахад чухал хэрэглэгдэхүүн болох боловч үг эрж олоход хялбар бус талтай. Харин Өвөр монголын эрдэмтэн Раашцэрэн тус толийг цагаан толгойн дараалалд оруулж, монгол төвд толгой үгийн хэлхээс хийж хэвлүүлсэн нь ашиглахад их дөхөмтэй болжээ²¹.

Монголчуудын төвд хэлнээс ном зохиол орчуулж ирсэн олон жилийн арвин их туршлагын үр дүн болох энэхүү толь бичигт дэвшүүлсэн орчуулгын тухай онол сургаал үе үеийн эрдэмтэн гүүш нарын орчуулгын гарын авлага болсоор ирэв. “Мэргэд гарахын орон” толь бичигт "үгд үл итгэн утгад итгэн"²² орчуулах явдлыг чухалчилсан нь орчин цагийн орчуулгын онолын зарчмын гол асуудалтай нийцэж байна. Мөн зохиолын агуулгыг засаж өөрчлөлгүй санааг үнэн бодтой гаргах, зохиолыг сайтар тунгаан нягталсан хойно буюу сэжгийг тасалсан хойно орчуулах, үг нэмэх, үг хасах зэрэг хэл зүй, үгсийн сангийн хувиргал хийх, эхийн утгыг төгс гаргах үүднээс үгийн байрлалыг сольж орчуулах, үгийг салангид утгаар бус харин "урд хойт үгийг шинжилсний" дараа буюу хам сэдвийг анхааран үзэж хөрвүүлэхийг заажээ²³. Түүнчлэн уран зохиолын амин

²⁰ Монголын уран зохиолын тойм (XVII-XVIII зууны үе), Хоёрдугаар дэвтэр, Редактор Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд, Улаанбаатар, 1977, 386.

²¹ Oyun-i todurayuluuci erdeni erike, Degedy dooradu debter, Цыгь mongyol-un soyul-un keblel- ын qoriy-a, 1998.

²² Merged yarqu yin oron, Rinčinγava, Sečençoytu tobčilan emkitgebe, ьндьсьтен-ь keblel-ын qoriy-a, 1988, 1401-1402.

²³ Merged yarqu yin oron, Rinčinγava, Sečençoytu tobčilan emkitgebe, Цыгь mongyol, 1983, 16.

сүнс болох сэтгэл хөдөлгөх чадалт үгсийг сонгон орчуулах, шүлгэлсэн зохиолын тухайд бадгийн урт охрыг тэгшлэн толгой холбон орчуулахыг заан тэмдэглэхийн сацуу нэр томъёог хэрхэн орчуулах талаар өгүүлсэнийг эш татвал “Бас бандид шидтэн ба хаан түшмэл тэргүүтэн бодгалисын нэр хийгээд орон, цэцэг жимс тэргүүтний нэрийг орчуулбаас мэдэхүйеэ бэрх бөгөөд өгүүлэхүйеэ амаргүй болох тул нэрийн эх сүүл аль зохистод бандид хийгээд цэцэг хэмээх тэргүүтэн алианаа өгүүлэх нэгэн нэрийг нэмж, мөнхүү энэтхэг буюу төвд нэрээр тавьтугай” гэж төвд хэлнээс монгол хэлнээ орчуулах арга зүй бүхий орчуулгын онолын чухал асуудлыг сөхөн тавьжээ. “Мэргэд гарахын орон” хэмээх нэр томъёоны толь бичгээс гадна XVII-XX зууны үед төвд-монгол хэлний олон толь бичиг гарсан нь төвд хэлнээс нэр томъёо орчуулах чухал гарын авлага болж байв.

Төвд хэлнээс ном судар орчуулах үйл хамгийн их өрнөж байсан 17-19 зууны үед үг үсэг бүрийг мөрдөн орчуулсан судрын орчуулгын зэрэгцээ иргэний агуулга бүхий зохиолыг утга төгс уран сайхан орчуулах хандлага улам боловсрон хөгжив. Энэ үеийн орчуулгын бас нэг онцлог бол буддын шашин, утга зохиолын нэр томъёоны орчуулга нэг мөр болж тогтворжиж ирсэн явдал юм. Үүнийг “Мэргэд гарахын орон” толь бичиг гарахаас өмнөх үеийн орчуулга тухайлбал монгол Ганжуурын 26 дугаар боть дахи “Билгийн чанад хүрсэн зуун мянган тоот” судрын зарим жишээн дээр харьцуулж үзье.

	Төвд нэр томъёо	“Билгийн чанад хүрсэн зуун мянган тоот”	“Мэргэд гарахын орон”
1	Rnam par shes pa	Мэдэхүй	Тийн мэдэхүй
2	'du shes	Сэтгэхүй	Хуран мэдэхүй
3	'du byed	Үйлдэхүй	Хуран үйлдэхүй
5	Yan lag	Мөч	Гишүүн
6	Snyom par 'jug pa	Тэгш оролдохуун	Тэгш орогч, тэгш оролдох, тэгш орох
7	Gzugs med pa'I khams	Өнгөгүй ертөнц	Дүрсгүйн орон
8	Mi dmigs pa	Үл сэтгэгдэх	Зоригдош үгүй, зоригдохуй үгүй, үл зоригдох
9	Yid	Сэтгэл дур	Сэтгэл
10	Gzugs	Бие, дүрс	Дүрс
11	Stong pa nyid stong pa nyid	Хоосонхүү хоосон	Хоосонхүү хоосон чанар
12	Don dam pa stong nyid	Үнэмлэхүй хоосон	Үнэмлэхүй хоосон чанар

13	Khams	Язгуур	Махбод
14	Snying rje	Өршөөнгүй	Нигүүлсэхүй

Энэ хүснэгтээс “Билгийн чанад хүрсэн зуун мянган тоот” дахи дурдсан нэр томъёоны орчуулга “Мэргэд гарахын орон” толь бичгээс зөрүүтэй, нэг мөр болоогүй байсныг харж болно.

Тэгвэл ХХ зуун гарсаар буддын шашны нэр томъёоны орчуулгад ямар өөрчлөлт гарсныг нэрт дуун хөрвүүлэгч С.Шагж гуайн /1886-1938/ орчуулгын жишээн дээр авч үзье. “Монгол үсгийн дүрмийн толь бичиг”, “Эрэхүй хялбар болгон зохиосон үгийн тайлбар чандманийн чимэг” толь бичиг, “Монгол бичиг сурах дөт зам” хэмээх сурах бичиг зохиосон нэрт толь зүйч, хэл шинжлэлтэн, дуун хөрвүүлэгч Шагж гуай төвдийн эрдэмтэн Туган Лувсанчойжинямын “Шэлжи мэлон” /”Болорын толь”/ хэмээх буддын гүн ухааны түүхийн алдарт зохиолыг 1924 онд төвд хэлнээс монгол хэлнээ орчуулжээ. Түүний орчуулгад уйгарын орчуулгын уламжлал туссаныг дараах хүснэгтээс харж болно.

№	Төвд нэр томъёо	“Мэргэд гарахын орон”	“Болорын толь”
1	bsam gtan	Дияан	Дияан
2	Ting nge ‘dzin	Самади	самади
3	Yul	Вишай	вишай
4	Rig ‘byed	Вед	вед
5	Gang zag	Бодгаль	бодгаль
6	Mngon mdzod	Авидарма	авидарма
7	Lung	Бивангрид	Бивангрид
8	Bgra bcom	Архад	Архад
9	Bram ze	Бярман	бярман
10	Dge slong	Аяга тэхимлиг	Аяга тэхимлиг
11	Phar phyin	Барамид	Барамид
12	Byin rlabs	Адистид	Адистид
13	Nyan thos	Шраваг	шраваг

Нөгөөтэйгүүр Шагж гуайн орчуулгад уламжлалаас хазайсан буюу “Мэргэд гарахын орон” толь бичигт тогтоосон дүрэм журмыг мөрдөөгүй тал ч харагдана. Тухайлбал тогтсон тааллын нэрийг орчуулсан байдлыг авч үзвэл төвд нэр томъёог орчуулахгүй зээлж авсан байна. Үүнийг дараах хүснэгтээс харж болно.

№	Төвд нэр томъёо	“Мэргэд гарахын орон”	“Болорын толь”
1	Sems tsam pa	Сэтгэлийн төдийтөн	Сэмзамба
2	Bye smra	Өвөрмөц өгүүлэгчин	Жэмра
3	Mdo sde ba	Судрын аймагтан	Додэва

4	Thal ‘gyur ba	Хэтрүүлэгчтэн	Талжурва
5	Dbu ma	Төв үзэлтэн	Ум
6	Rang rgyud pa	Өөрийн үндэстэн	Ранжудва
7	Dngos smra ba	Бодтойяа өгүүлэгч	Оймрава

Үүнээс гадна агчэн /sngags chen/, агчан /sngags ‘chang/, агшад /sngags bshad/, банчэн /pan chen/, бонлов /dpon slob/, гаашиба /bka’ bzhi ba/, гавж /bka’ bcu/, гүнчэн /kun chen/, гэвш /dge bshes/, жалва /rgyal ba/, ловон /slob dpon/, ханчэн /mkhan chen/, цорж /chos rje/, жово /jo bo/, жэ /rje/, дүвчэн /drub chen/ зэрэг олон үгийг зээлж авчээ. Шагж гуай эдгээр үгийг Аюуш гүүшийн галигаар галиглаж, улмаар төвд бичлэгийг харгуулан зэрэгцүүлж тавьсан нь зөв уншихад их тустай болсоныг тэмдэглэх хэрэгтэй.

Шагж гуай нэг талаас санскрит бичлэгийг сэргээн буулгах уламжлалыг баримталжээ. Нөгөө талаас шарын шашны хүчтэй нөлөөн доор хүрээ хийдийн лам нар хэл яриандаа төвд үг хэллэгийг өргөн хэрэглэж байсан цаг үеийн байдал түүний орчуулгад туссаныг харж болно.

Тодорхой эрдэм ухааны хүрээнд салаа утгагүй, товч тодорхой, үг зүйн хувьд зөв хэлбэржсэн, найруулга зүйн бүх шаардлагыг хангасан, сэтгэл хөдлөлийн өнгө аяс илэрхийлдэггүй үгийг нэр томъёо²⁴ гэх бөгөөд манай уламжлалт орчуулгад буддын шашны нэр томъёог үгчлэх, утга дүйлгэн орчуулах, гадаад үгийг зээлэх арга аль аль нь байжээ.

Социализмийн үед манай улсад шашин номын үйл ажиллагаа бараг зогсонги байдалд орж, 1990 оноос хойш монголчуудын үндэсний шашин соёлоо судлах ажил дахин сэргэж, үүнийг дагаад төвд хэлнээс ном зохиол орчуулах ажил ч дэлгэрсэн билээ. Өнөө үед буддын шашны ном судрыг төвд хэлнээс дахин орчуулахаас гадна монгол бичгээр уламжилж ирсэн орчуулгыг шүтэж, орчин цагийн монгол хэл аялгуунд ойртуулж буулгах хандлага ч буй боллоо. Зонхов богдын зохиосон “Ламрим” буюу “Бодь мөрийн зэрэг” болон “Ламрим”-ийн тайлбарын жишээн дээр нэр томъёог орчуулах талаар ямар хандлага буйг авч үзье.

№	Төвд нэр томъёо	Ламримын орчуулга ²⁵	Ламримын орчуулга ²⁶	Ламримын орчуулга ²⁷	Ламримын тайлбар ²⁸	“Мэргэд гарахын орон”,
---	-----------------	---------------------------------	---------------------------------	---------------------------------	--------------------------------	------------------------

²⁴ Ц.Шагдарсүрэн, Эх хэлээ эвдэхгүй юмсан...Монгол хэлний мөн чанар, онцлог, одоогийн байдал, олон нийтийн эх хэлний боловсрол, сөрөг үзэгдэл, /Нэмэн зассан хоёрдугаар хэвлэл/, Хянан тохиолдуулсан Ш.Чоймаа, Улаанбаатар, 2010, 128.

²⁵ Богд Зонхов, Бодь мөрийн зэрэг буюу гэгээрэлд хүрэх зам, Г. Аким нар бүтээв, Тайвань, 2007.

²⁶ Богд Зонхаба, Бага бодь мөрийн зэрэг, бурханч лам Г.Пүрэвбат орчуулав, БНСУ, 2002.

²⁷ Зонхава Лувсандэва, Их бодь мөрийн зэрэг, 1-3 дэвтэр, Түвд хэлнээс орчуулсан Т.Булган, Ариутган шүүсэн гавж Ө.Гүндсамбуу, Д.Цэрмаа, Улаанбаатар, 2004.

²⁸ Гэвш ламтан Равдан, Еши Зундуй ламтан, Дээд номын рашааны шим хэмээх бодь мөрийн зэргийн зохиол ба түүний тайлбар, Англи болон түвд хэлнээс орчуулсан Ч. Хатанбаатар, Улаанбаатар, 2011.

		№1	№2	№3		бусад толь
1	Dge ba'I bshes bsnyen	Багш	Буяны садан	Буяны садан	Буяны садан, багш	Буяны садан
2	Skye bo gsum	Гурван төвшний хүн	Гурван төрөлхтөн	Гурван төрөлхтөн	Гурван төрөлхтөн	Гурван төрөлхтөн
3	Bslab pa gsum	Гурван заавар журам	Гурван суртал	Гурван суртгаал	Гурван суртахуун	Гурван суртахуун
4	Tshul khrims	Ёс зүй, ёс суртахуун	Шагшаабад	Ёс суртахуун	Шагшаабад /ёс суртахуун/	шагшаабад
5	Ting nge 'dzin gyi bslab pa	Сэтгэл төвлөрлийн заавар журам	Самадийн суртал	бясалгалын суртгаал	Сэтгэлийн төвлөрөл, бясалгал /самади/	самадийн суртахуун
6	Shes rab kyi bslab pa	Билиг оюуны заавар журам	Билгийн суртал	Билгийн суртгаал	Билгүүний суртахуун	Билгийн суртахуун
7	'du shes drug pa	Зургаан төрлийн төсөөлөл	Зургаан хуран мэдэл	Зургаан хур мэдэл	-----	Зургаан хуран мэдэл
8	Rang 'byor	Өөрөө бүрдүүлэх боломж	Өөрийн учрал	Чөлөө учрал	Чөлөө учрал	өөрийн учрал
9	Dal 'byor	Завшаан боломж	Чөлөө учрал	Чөлөө учрал	Чөлөө учрал	Чөлөө учрал

Дээрхи жишээнээс ажиглавал эхний орчуулгад нэр томъёог орчуулсан байна. Энэ нь бурханы шашны онол сургаалыг нийт хүмүүст хүргэж ухаж ойлгоход хялбар дөхөм болгохыг эрмэлзсэнтэй холбоотой болов уу. Тухайлбал дээрх хүснэгтийн 9 дүгээрт буй Dal 'byor гэсэн төвд үгийг “завшаан боломж” гэж орчуулжээ. Гагцхүү түүнийг “чөлөө учрал” гэж орчуулах уламжлал байгаа учир түүнийг хэрэглэж хэвшүүлэх тухайд наад зах нь хаалт буюу зүүлтэд хийж оруулбал буддын утга зохиолын нэр томъёог хойч үедээ уламжлуулахад тустай болох нь дамжиггүй. Бодь мөрөөр замнаж гэгээрэлд хүрэхэд хүний төрлийг олох буюу “чөлөө учрал”-ыг олохыг

бурханы шашинд их чухалчилдаг²⁹. Тиймээс “чөлөө учрал” гэж орчуулсан нь маш нарийн утга учиртай, оносон орчуулга ажээ. Энэ үгийг “Хорин наймтын тайлбар толь”-д “Учрал- аливаа амьтны ерөөл барилдлагаар учирсаныг учрал хэмээмүй. Бас аливаа өдрийн одон гарагийн тохиолыг учрал хэмээмүй. Чөлөө- хэрэг үгүй сул аху үеийг чөлөө хэмээмүй. Бас аливаа үйлдвэрийн хүмүүн нэгүүд сэгхийж амасхийхийг чөлөө хэмээмүй. Товчилвоос яаралтай үгүй бөгөөд яригтаа жаргалтайг чөлөө хэмээмүй” гэж тайлбарласныг тунгаан үзвэл яах аргагүй дүйсэн нэр томъёо болох нь харагдана. Бусад орчуулгын тухайд уламжлалыг илүү баримталжээ.

Өнөө үед буддын шашны ном зохиолыг төвд хэлнээс гадна бусад хэлнээс ч орчуулж байна. Тухайлбал англи хэлнээс монгол хэлнээ буддын шашин гүн ухааны нэр томъёог орчуулахад уламжлалыг баримталсан жишээ ч тааралдана. Залуу эрдэмтэн судлаач Ч.Хатанбаатарын орчуулгаас жишээ авч үзье. Тэр бээр “The essence of Tibetan Buddhism” хэмээх Түвдэн-Ешэ ламын зохиолыг монгол хэлнээ орчуулахдаа нэр томъёог дүйлгэн орчуулах, тайлбарлан орчуулах аргыг хэрэглэжээ. Тухайлбал: “renunciation” гэсэн үгийг “магад гарахуйн сэтгэл” гэж хөрвүүлжээ³⁰. Энэ “магад гарахуйн сэтгэл” гэж орчуулсан үг төвд хэлний “nges ‘byung” гэдэг нэр томъёотой дүйж байгаа бөгөөд “renounce” гэдэг үйл үгийг “магад гарахуй- орчлонгоос уйсахуй” гэж тайлбарлан орчуулсаныг зөв зүйтэй гэж бодож байна. Цаашилбал англи хэлний “path to liberation” гэснийг “тонилохуйн мөр” гэж буулгасан нь төвд хэлний “thag ba’i lam” гэсэн нэр томъёотой утга дүйх учир зөв оноожээ. Буддын шашны ном зохиолыг орчуулахад уламжлалт нэр томъёог авч хэрэглэх нь их нийцтэй болохыг энэ орчуулга харуулж байна. Бас “ego” гэсэн үгийг хэрхэн орчуулсаныг авч үзье. Латин хэлнээс гаралтай, “би” гэсэн утгатай энэ үгийг сүүлийн үед гарч буй орчуулгын зохиолуудад зээлж авсан нь их тааралддаг. Орчуулагч Ч.Хатанбаатар “ego mind” гэсэн нэр томъёог “миниймхийрэн барих үзэл”, “би-д барих үзэл” гэж орчуулжээ. Энэ үг төвд хэлний “bdag ‘dzin” гэсэн нэр томъёотой утга дүйж буй тул тийнхүү оноосон бололтой. Тухайлбал “To be free from ego mind and the bondage of samsara” гэсэн өгүүлбэрийг “би-д барих сэтгэл хийгээд сансарын хүлээснээс гэтлэх”³¹ гэж орчуулжээ. Буддын шашны нэр томъёог орчуулахад “...эхлээд тухайн зүйлийг заасан хуучин /уламжлалт/ нэр томъёо байсан эсэхийг лавлан үзвэл зохилтой. Энэ нь чухамдаа “айлаас эрэхээс авдраа уудла” гэдэгтэй зарчим адил,

²⁹ Чөлөө учрал- найман чөлөө, арван учралыг ийнхүү нэрлэдэг. Найман чөлөө нь там, бирд, адгуус, тэрс үзэлт, урт наст тэнгэр, буруу үзэлт, бурхан эс заларсан, хэлгий байх зэрэг чөлөөгүй найман орныг тэвчихийг хэлнэ. Арван учрал нь хүний төрлийг олсон байх, орны төв дунд төрөх, эрхтэн бүрэн байх, хилинцэт үйлээс няцах, бурханы шашинд сүсэглэх буюу өөрийн таван учрал; бурхан заларсан, бурхан дээдийн номыг зарлигласан, бурханы шашин оршсон, бурханы шашинд орсон, буяны садан багшийг шүтсэн байхыг бусдын таван учрал гэдэг.

³⁰ Түвдэн Ешэ лам, Бурханы шашны охь шим, Бодь мөрийн гурван эрхэм хийгээд тарнийн ёсны удиртгал, Улаанбаатар, 2007, 8.

³¹ Түвдэн Ешэ лам, Бурханы шашны охь шим, Бодь мөрийн гурван эрхэм хийгээд тарнийн ёсны удиртгал, Улаанбаатар, 2007, 12.

хэлнийхээ дотоод нөөц боломжийг уудлан ашиглаж байгаа хэрэг”³² гэж эрдэмтэн Ц.Шагдарсүрэн багшийн бичсэнтэй бид санал нэг байна.

Дүгнэлт

13-14 зууны үеэс өнөө үе хүртэл уламжлан ирсэн төвд хэлнээс орчуулсан арвин их судар бол монголын Буддын шашны нэр томъёог судлах чухал хэрэглэгдэхүүн болно. Нэн ялангуяа “Мэргэд гарахын орон” хэмээх нэр томъёоны толь бичиг буддын утга зохиолын нэр томъёоны орчуулгыг журамлан тогтоосон чухал гарын авлага болох учир өнөө үед ч даган мөрдвөл зохилтой.

Манай шинэ үеийн орчуулагчид “Мэргэд гарахын орон” толь бичгээр журамлан тогтоосон нэр томъёоны орчуулгаас ямар нэг хэмжээгээр хазайхад тухайн цаг үеийн байдал нөлөөлж байсныг Шагж гуайн орчуулгын туршлагаас харж болно.

1990 оноос хойш буддын шашин гүн ухааны нэр томъёог орчуулж буй байдлыг ажиглавал нэг талаас уламжлалыг тусгаж орчуулах, нөгөө талаар утга дүйлгэн орчуулах хандлага байна.

Буддын шашны утга зохиолыг англи хэлнээс орчуулахад уламжлалт нэр томъёог хэрэглэх, шаардлагатай газар тайлбарлах зэрэг ололт байгааг тэмдэглүүштэй.

Resume

A quite many of sutras that have been passed down the ages to the present time since 13-14th century, serve as important tools for the study of Buddhist terms. Especially, a terminology dictionary "Merged yarqu yin oron" should be used extensively as an important handbook that defined the rules to translate literary terms.

Shagji and other translators' experience show that the time circumstances had an influence on translators of new ages to divert in certain extent from the established rules of terminological translations.

Two trends have been observed in the translation of Buddhist religious and philosophical terms: on way is paying more attention on reflecting the tradition, and the other way is putting more significance on matching the meaning.

It is also remarkable that traditional terms are being used in English-Mongolian translation of Buddhist literature, and in necessary places references are being made in the text.

³² Ц.Шагдарсүрэн, Ц.Шагдарсүрэн, Эх хэлээ эвдэхгүй юмсан...Монгол хэлний мөн чанар, онцлог, одоогийн байдал, олон нийтийн эх хэлний боловсрол, сөрөг үзэгдэл, /Нэмэн зассан хоёрдугаар хэвлэл/, Улаанбаатар, Хянан тохиолдуулсан Ш.Чоймаа, 2010, 130.